

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2023.06.26

Улаанбаатар хот

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Биелэлт	Хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	<p>1.1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;</p>	<p>-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт- 100</p>	<p>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлах зорилгоор АТГ-аас бэлтгэн гаргасан зураг хуудас, тараах материалыг иргэдэд хүргэж ажилласан. Энэ ажлын хүрээнд 15 төрлийн сурталчилгааны материалыг хувиалан тараасан. "Авлигатай тэмцэх газар", "АТГ-Олон нийтийн төв" пэйж хуудсанд төрийн өмчийн 159 байгууллагын төрийн албан хаагчид нэгдэж, мэдээ, мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлсэн. МУ-ын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авлигатай тэмцэх 5 ажиллагааг хэрэгжүүлж эхлүүлсэнтэй холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж буй "Шүгэл" ажиллагаанд нэгдэж сурталчилгааны 2000 ширхэг материалыг 43 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр дамжуулан иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна.</p>	70
		<p>1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын</p>	<p>-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён</p>	<p>Ёс зүйн зөрчилгүй хамт олон аян зохион</p>	<p>Төрийн байгууллага, албан тушаалтны албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдүүлэх, сурталчлан таниулах, Ёс зүйн хэм</p>	30

	<p>онцлогт тохируулан зохион байгуулах;</p>	<p>гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>байгуулсан байх</p>	<p>хэмжээний зөрчил, авлигын шалтгаан нөхцөлийн өнөөгийн байдал, тэдгээрийг арилгах, таслан зогсоох, нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигыг үл тэвчих үзлийг төрийн албан хаагчдад төлөвшүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн байгууллагын дунд "Ёс зүйн зөрчилгүй хамт олон аян"-ыг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 онд зохион байгуулах аяны бэлтгэл ажлын хүрээнд удирдамж, төсөв төслийг боловсруулан, шаардлагатай сурталчилгааны материалыг бэлтгэн ажиллаж байна.</p>	
	<p>1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;</p>	<p>-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Сар бүр мэдээллийг шинэчилсэн байх</p>	<p>Авлигын эсрэг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх агуулга бүхий мэдээлэл агуулсан "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарыг 43 хорооны байранд байршуулж, давхардсан тоогоор 4500 гаруй иргэдэд сурталчлан ажиллаж байна.</p>	<p>70</p>
	<p>1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг</p>	<p>-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube сувар), мөн</p>	<p>3 төрлийн сурталчилгааны материал хийж сурталчилсан байх</p>	<p>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлах зорилгоор АТГ-аас бэлтгэн гаргасан 15 төрлийн сурталчилгааны материалыг хувиалан төрийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан.</p>	<p>30</p>

		сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.			
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	4 удаа сургалт зохион байгуулсан байх	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлж ёс зүйн зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2 удаагийн сургалт зохион байгуулж 275 албан хаагчдыг хамруулсан. Тухайлбал: "Авлигын нөхцөл байдал, анхаарах асуудал" сэдэвт сургалтыг 2023 оны 4 дүгээр сард зохион байгуулж хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч, эмч, цагдаа зэрэг нийт 250 албан хаагчдыг хамруулсан бөгөөд үүнээс 20 нь шинээр томилогдсон албан хаагч байна. Мөн дүүргийн хэмжээнд ХАСХОМ, ХАСУМ мэдүүлэгч гаргагч нийт 262 албан тушаалтанд АТГ-тай хамтран 2 удаагийн сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.	70
		2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;	1 удаа өдөрлөг зохион байгуулах	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний	-

		зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	-Тайланд нотломжийг хавсаргасан байх.		дагуу 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Хамтын ажиллагааны гэрээ авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс, тасгийн шууд худалдан авалт бусад зохион байгуулалттай чиг үүргийн хүрээнд иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор "Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт гэрээ байгуулах журам"-ыг баталж, мөрдөн ажиллаж байна. Журамд "Гэрээний төсөлтэй танилцаж санал өгөх, гэрээ байгуулах албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл үүссэн бол гэрээний төсөлтэй танилцахаас татгалзаж, "Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг эрх бүхий албан тушаалтанд гаргана" гэсэн заалт тусган,	70

					<p>хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Засаг даргын Тамгын газраас иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай нийт 151 гэрээг холбогдох хуульд нийцүүлэн байгуулсан. Үүнд: Ажил гүйцэтгэх гэрээ-101, Ус ашиглах-6, Түрээсийн гэрээ-3, Худалдах, худалдан авах гэрээ-29, Хог ачилтын гэрээ-1, Хамтран ажиллах гэрээ-4, Хөлсөөр ажиллах гэрээ-7 байна. Байгуулагдсан гэрээний хүрээнд авлига, ашиг сонирхолтой холбоотой үүссэн зөрчил илрээгүй байна.</p>	
		<p>3.2."Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх</p>	<p>-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.</p>	<p>Журмын хэрэгжилтийг хангасан байх</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хяналтад авч ажиллаж байна. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар нь shd.mn цахим сайтаар үйл ажиллагаагаа иргэдэд нээлттэй сурталчлан ажиллаж байгаа бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 80.0 хувьтай үнэлэгдсэн. Мөн Авлигатай тэмцэх газартай хамтран 3 удаа сургалт зохион байгуулж, 537 гаруй албан хаагчдыг хамруулснаас гадна 2023 оны 4 дүгээр сард зохион байгуулсан хяналт шалгалтын ажилд дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа</p>	70

					байгууллагуудыг татан оролцуулж, хамтран ажиллаа. АТГ-аас хийсэн хяналт шалгалтын хүрээнд ирүүлэх зөвлөмжийн дагуу шаардлагатай ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлж, үр дүнг тооцсон байх	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, 14, 23, 30, 35, 22, 33 дугаар хороонд байршуулж, нийт 10 ширхэг посс машин нэмж байршуулан 37590 иргэний 48955000 төгрөгийг цахим төлбөрийн хэрэгсэл ашиглан төлүүлсэн. Мөн Төрийн үйлчилгээг иргэдэд ойроос, хурдан шуурхай үзүүлэх зорилго бүхий "ХурДан" цэгүүдийг Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 5-6 цэгийг байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар 22-ын товчооны авто худалдааны цогцолбор, Баянхошуу тойргийн уулзварын Номин дэлгүүрт байгуулсан. 3 дахь цэгийн СХД-ийн 22 дугаар хороо, Орбитын тойрогт байршуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Тус үйлчилгээний цэгээс 94 төрлийн лавлагаа, тодорхойлолтоос гадна гадаад паспорт, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх захиалах, солих, нөхөн олгох, тээврийн хэрэгслийн төлбөр, татвар гэх мэт төрийн 39 байгууллагын 440 гаруй үйлчилгээг авах боломжтой болсон.	70

4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;

-2-оос доошгүйг зохион байгуулсан байх;
-Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;
-Тайланд нотломжийг хавсаргасан байх

Төрийн байгууллагуу дын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан байх



2023 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлага 05 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд болохтой холбогдуулан тус дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалтыг 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Сургалтын зорилго нь Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэрэг, тус гэмт хэргийн шалтгаан нөхцөл, үр дагаврыг ойлгох, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх хандлагыг алба хаагчдадаа таниулах, авлигатай тэмцэх үйл ажиллагааг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх, нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Тус сургалтын үеэр "Авлигын хор хөнөөл, шалтгаан нөхцөл", "Авлигын гэмт хэрэг" зэрэг сэдвийг хөндөж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Сургалтад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Н.Батчулуун, нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын Батлан хамгаалах хууль тогтоомж, хяналт шинжилгээ хариуцсан ахлах офицер хурандаа М.Мөнгөнтулга, дүүргийн ЗДТГ-ын дарга Д.Төмөрбаатар, Цэргийн штабын дарга дэд хурандаа Б.Нямгэрэл


					болон дүүргийн 43 хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч, ЗДТГ, ЭМГ, Цагдаагийн газрын алба хаагчид буюу цэрэг татлагын товчоонд ажиллах нийт 250 гаруй албан хаагчид хамрагдсан.	
		4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	Иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, арга хэмжээ зохион байгуулах	Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэдийн санал, шүүмжлэлийг хүлээн авах, бодлого үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон нийтийн оролцоог хангах зорилгоор санал асуулгыг байгууллагын соёл, албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, үйлчилгээний соёл гэсэн агуулгын хүрээнд боловсруулж 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд авахаар ажиллаж байна. 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 36 хорооны 303 иргэдээс цахим (QR)-аар, 2195 иргэн цаасан хэлбэрээр саналаа өгсөн байна. Иргэдээс авах санал асуулгын судалгааг 6 дугаар сарын 30-ны өдөр дуусгавар болгож саналыг 7 дугаар сарын 20-ны дотор нэгтгэн, үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээг төлөвлөхөөр ажиллаж байна.	30
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл,	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал	Албан хаагчдын санал санаачилгыг төлөвлөгөөн	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг 5 зорилгын хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөж эхний хагас жилийн байдлаар	70

санаачилга өрнүүлэх	хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	санаачилгыг хэлэлцсэн байх; -Арга хэмжээнд удирдлагын -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	д тусгаж хэрэгжилтийг хангасан байх	100 хувийн биелэлттэй 0, 70 хувийн биелэлттэй 9, 30 хувийн биелэлттэй 5, хугацаа болоогүй 1 арга хэмжээ байна.	
	5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Санал хүргүүлсэн байх	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2023 оны 4 дүгээр сард Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Худалдан авах ажиллагааны алба, ОНӨААТҮГ болон зарим төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний зөвлөмж, чиглэлийг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд нэмж тусгахаар ажиллаж байна.	30
	5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх, -Тайлагнасан байх.	Үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийг www.shd.mn сайтад болон khutulbur.iaac.mn цахим санд байршуулсан байх	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг 2 дугаар сард баталж дүүргийн shd.mn цахим сайтын "Ил тод байдал" цонхны "Авлигатай тэмцэх үйл ажиллагаа" цэсэд байршуулж иргэдэд сурталчлан ажиллаж байна. Мөн Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалтны ёс зүйн дүрмээс гадна	70

					Авлигатай тэмцэх газраас гаргасан авлигын эсрэг сурталчилгааны материалыг байршуулан тогтмол сурталчилж байна.	
Хувь						57.6



ТАНИЛЦСАН:
 СХД-ИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 ДАРГА  Д.ТӨМӨРБААТАР
 ТАЙЛАН ХЯНАСАН:
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 ДАРГА  Т.БАТ-ОРГИЛ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:
 ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН  Г.ОДБИЛЭГ